

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
ЗӨВЛӨМЖ

Нийгмийн даатгалын ерөнхий газарт

2020 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Зөвлөмж 1. Нийгмийн даатгалын архивыг цахимжуулах хүрээнд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг бүрэн дижитал бүртгэлд шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх

Нийгмийн даатгалын байгууллагаас нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг цахимжуулах ажлын хүрээнд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолтыг төрийн үйлчилгээний цахим “ТҮЦ” машинаас олгодог. Гэвч зарим тохиолдолд дээрх тодорхойлолтыг баримт бичгийн бүрдэл хангахгүй гэж үзэн нийгмийн даатгалын байгууллагаар дахин баталгаажуулах шаардлага гарч байна. Уг тодорхойлолт нь иргэнд зөвхөн мэдээлэл болох хэмжээнд ашиглагдаж байгаа одоогийн нөхцөл байдлыг өөрчилж, архивын сан хөмрөгт байгаа шимтгэл төлөлтийг бичиг баримтыг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн нийгмийн даатгалын байгууллага хооронд үйлчилгээг цахимжуулсан гэх боловч тэтгэвэр, тэтгэмжээ тогтоолгохын тулд иргэд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс хооронд биечлэн очиж архивын материалаа бүрдүүлэх, 1995-2005 оны хоорондох ажил олгогч болон даатгуулагчийн мэдээлэл програмд бүрэн ороогүй гэх шалтгаанаар удаа дараа нааш цааш явах нөхцөл байдал хэвээр байна. (Тухайлбал, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт)

Зөвлөмж 2. Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтад иргэний үнэмлэхний хуулбар, лавлагааг оруулсан хуулийн холбогдох зохицуулалтыг өөрчлөх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар тэтгэвэр тогтоолгохтой холбоотой үйлчилгээг үзүүлэхэд иргэдээс иргэний үнэмлэхний хуулбар, лавлагаа авахаар тусгасан нь цахим технологи нэвтэрч буй өнөөгийн нөхцөлд иргэдэд чирэгдэл учруулж байна. Төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, цахим мэдээллийн санг үүсгэн, төрөөс олгодог бичиг баримтыг цахимжуулснаар сүлжээ ашиглан төрийн үйлчилгээг саадгүй, түргэн, шуурхай, авлигын эрсдэлгүй хүргэх бодлогыг хэрэгжүүлэх боломжтой.

Зөвлөмж 3. Тэтгэвэр тогтоолгохтой холбоотой лавлагаа олгох чиглэлээр архивын байгууллагатай нягт хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог хангах, хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг эрчимжүүлэх

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Архивын ерөнхий газар хооронд 2017 онд “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан боловч гэрээнд иргэдэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх талаар нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байна. Төрийн байгууллагууд уг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх чиглэлээр хэд хэдэн удаагийн уулзалт хийснээр хамтын ажиллагаа хязгаарлагдаж өнөөг хүртэл асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй байна.

Архивын ерөнхий газрын удирдлагуудтай уулзаж, тухайн үйлчилгээний чиглэлээр лавлагаа гаргах асуудлаар мэдээлэл солилцоход дүүргийн нийгмийн даатгалын байцаагчид тогтвор суурьшил муутай, шинээр томилогдсон байцаагчид чадавхжаагүй, хаана, ямар архивт, ямар бичиг баримт хадгалагдаж байгаа талаар бүрэн судлаагүй, архивын байгууллагаас хүргүүлсэн цахимжуулсан үйлчилгээний жагсаалт дүүргийн хэлтэс бүрт байхгүй, нийгмийн даатгалын байцаагчид ижил байгууллагад ажиллаж байсан иргэдэд харилцан адилгүй шаардлага тавьдаг(тухайлбал, гутлын үйлдвэрт хамт ажиллаж байсан нэг иргэнд ажилласан хугацааны мэдээллийг 3 жилээр, нөгөө иргэнд мэдээллийг 10 жилээр шүүлгэсэн байхыг шаарддаг) гэх асуудал байдаг талаар дурдаж байлаа.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд дүүргийн нийгмийн даатгалын нэгжийн дарга нарыг нэгдсэн мэдээлэл, арга зүйгээр хангах, дээрх хоёр байгууллагын хамтарсан сургалт зохион байгуулах,

архивын байгууллагад байгаа мэдээллийг цахим сүлжээгээр авах асуудлыг судлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмж 4. Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгохтой холбоотойгоор бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг эргэж нягтлах, шаардлагатай тохиолдолд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх

Тухайлбал, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т дурдсан тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтад “даатгуулагч 1995 оноос өмнө ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр”-ээ бүрдүүлэхээр тусгагдсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 163 дугаар тушаалаар баталсан журмын дагуу хөдөлмөрийн дэвтэрт тэтгэвэр тогтоолгох иргэний овог, нэр, төрсөн он, сар, өдөр, ажилд авсан, ажлаас чөлөөлсөн он, сар, өдөр, тушаал шийдвэрийн дугаарын бичилт, баталгаажилт нь тухайн үед мөрдөж байсан журам, зааврын дагуу зөв бичигдсэн эсэхийг нягтлан шалгаж, хэрэв буруу зөрүү бичигдсэн, бичилт нь засвартай болон хөдөлмөрийн дэвтрийг шинээр хуулбарлан бичүүлсэн тохиолдолд архивын сан хөмрөгөөс тушаал, шийдвэрийн лавлагааг гаргуулах шаардлага тавьдаг. Тухайлбал, даатгуулагч иргэн хэд хэдэн байгууллагад ажилласан тохиолдолд даатгалын байгууллагын баримт бичиг нь нэг архивт хадгалагддаггүйн улмаас иргэд аймгийн, дүүргийн, нийслэлийн, цэргийн архивын сан хөмрөгөөс лавлагаа гаргуулах нөхцөл байдал үүсч байна. Иймд тухайн асуудлыг зохицуулж байгаа хууль тогтоомжийн холбогдох заалтад өөрчлөлт оруулах замаар чирэгдлийг багасгах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Зөвлөмж 5. Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох үйлчилгээ үзүүлж байгаа нийгмийн даатгалын байгууллагын ажилтныг чадавхжуулах, сургах, мэдээлэл арга зүйгээр тогтмол хангах ажлыг эрчимжүүлэх

Иргэн “Т” Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст тэтгэвэр тогтоолгох тухай бичиг баримтаа бүрдүүлэн өгөхдөө 2012-2018 онд ажиллаж байсан жилүүдийн нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн цалин, түүнтэй адилтгах орлогоор дараалсан 5 жилийн дундаж цалингаа сонгон тэтгэврээ тогтоолгох хүсэлт гаргасан байна. Гэтэл сүүлийн 20 жилийн дараалсан 5 жилийн цалин болох 2012-2018 оны бичилт дундаа тасарсан шалтгааны улмаас даатгуулагчийн сонгосон 5 жилээр тогтоогоогүй түүний 2007 оны 01 дүгээр сараас 2012 оны 01 сар хүртлэх дараалсан 5 жилийн цалин түүнтэй адилтгах орлогыг сонгон тэтгэврийг нь тогтоожээ.

Нийгмийн даатгалын байцаагчийн мэргэжлийн дадлага туршлага, мэдлэг чадвар дутмагаас даатгуулагчид аль болох таатай, үр ашигтай боломжийг хуулийн заалтад нийцүүлэн олгох талаар зөвлөн туслаагүй, даатгуулагчийн сонгоогүй 5 жилийн цалингаар тэтгэврийг дутуу тогтоож, иргэнд хохирол учруулсан нөхцөл байдал тогтоогдсон байдаг.

Зөвлөмж 6. Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгж дээр төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах хүрээнд иргэдэд зориулсан, тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц мэдээллийг олон арга хэлбэрээр иргэдэд түгээх, холбогдох журам, дүрмийг ил газар байршуулах арга хэмжээг авах

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллийн самбарт болон үйлчилгээ үзүүлж буй нийгмийн даатгалын байцаагчдын дэргэд холбогдох мэдээлэл байршсан эсэхийг үзэхэд шаардлага хангахуйц мэдээлэл огт байхгүй, тухайн үйлчилгээг үзүүлэхэд баримтлах журам, дүрэм нь ил тод, нээлттэй бус байна. Тухайлбал, Сонгинохайрхан дүүрэг дээр 15.30-18.00 цаг хүртэл ажиллах хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврээ тогтоолгох зорилгоор ирсэн 10 гаруй иргэд мэдээлэлгүйн улмаас учраа олохгүй бухимдалтай, хүлээлтийн шинжтэй байлаа.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгохтой холбогдох журмын дагуу бүрдүүлэх бичиг баримтын талаар мэдээлэл байхгүй, байршуулсан нэг хуудас мэдээллийн үг, үсэг нь мэдэгдэхгүй, гаргацгүй болсон байв. Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, зөвлөгөө мэдээлэл өгөх хэвлэмэл хуудас, танилцуулга гэх зэрэг иргэдэд хэрэгцээтэй мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлээгүй байна.